



Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал хэсэгт “Монголын ард түмэн бид ... төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж...”, Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, Арван зургадугаар зүйлийн 8 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй” гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд баталсан “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт”-ын 15 дугаар зүйлд “Хүн бүр соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, үүнийг хэрэглэх, өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах эрхтэй” гэдгийг, 2015 онд баталсан “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт”- ийн (2015 -2030) 36 - д ”соёлын олон янз байдлыг тэмдэглэн, бүх соёл, иргэншил нь тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг хангах тулгуур хүчин зүйл” гэдгийг тус тус хүлээн зөвшөөрсөн.

“Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” 2005 оны ЮНЕСКО-гийн конвенцын 13 дугаар зүйлд “соёлыг өөрсдийн тогтвортой хөгжлийн бүх шатны бодлогод нэгтгэхийг эрмэлзэх” гэдгийг, мөн “соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өвөрмөц хэв шинж, үнэт зүйлс, агуулгыг илэрхийлдгийн хувьд эдийн засгийн хийгээд соёлын аль алиных нь шинжийг агуулдаг” болохыг дурдан онцгой шинж чанарыг нь хүлээн зөвшөөрч, тэдгээрийг хөгжих чадавхыг нь дээшлүүлэх, хөхиүлэн дэмжихийг тус конвенцид элссэн улс орнуудад үүрэг болгосон байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4-т “...Монголын соёлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж”, 3.2.1-д “Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай

олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгон ... шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тус тус тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.2-т “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй улс болно. Монгол хүний оюуны бүтээлийг дэлхийн зах зээлд сурталчлах төсөл хэрэгжүүлнэ...” гэж, 4.2-т “Бүтээлч үйлдвэрлэл хөгжлийн бодлогын суурийг тавьж, бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлнэ” гэж, 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгон ... Зүүн хойд Азид хүлээн зөвшөөрөгдсөн соёл, шинжлэх ухааны төв болохыг ” тус тус зорьсон.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын гуравт заасан “Аж үйлдвэрийн сэргэлт” -ийн 3.6-д “... шинжлэн ухаанд суурилсан өндөр технологи, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэрийг хөгжүүлэх” бодлогыг хэрэгжүүлэхээр баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.4-т “бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдана” гэж, Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.3-т “... үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ” гэж, мөн Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд төрөөс соёлын талаар баримтлах бодлогын чиглэл нь “соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлого болон бусад хэлбэрээр дэмжих” гэж тус тус заасан нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Соёлын бүтээлч үйлдвэрлэл нь хүний бүтээлч сэтгэлгээ, мэдлэг, оюун болон технологийн дэвшлийг хамтатгасан эдийн засгийн гол хөдөлгөгч хүчин зүйлийн нэг болж байна.

2018 оны ЮНЕСКО-ийн тайланд¹ дурдсанаар соёлын бүтээлч үйлдвэрлэл нь жил бүр 2,2 их наяд ам.долларын орлого бүрдүүлж, дэлхий даяар 30 сая орчим хүнийг ажлын байраар ханган, дэлхийн улсуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 10%-ийг бүрдүүлж, экспортын нийт орлого нь 253 тэрбум ам.долларт хүрч, 2020 оны байдлаар дэлхийн нүүрсний экспортын хэмжээ (78.4 тэрбум ам доллар) байхад соёлын бүтээлч үйлдвэрлэлийн экспортын хэмжээ 6.4 дахин их буюу 500.0 тэрбум ам доллар байна.

Иймд дэлхийн нийтээр урлахуйн үйлдвэрлэл болох соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн бодлогыг санаачлан хэрэгжүүлж, цар тахлын дараа эдийн засгийг сэргээх, цаашид улс орны тогтвортой хөгжлийг хангах, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох,

¹ ЮНЕСКО-ийн 2018 оны тайлангаас

бүтээлч авьяас билгийг нөхөн сэргээгдэх нөөц байдлаар хөгжүүлэх гол салбараар нэрлэж байна.

Соёлын яамны захиалгаар 2021 онд хийсэн “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаа”-нд Монгол Улсын хувьд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт 11,697 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 5,665 нь идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж, 33,931 хүн ажиллаж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулж буй хувь нэмэр 481.4 тэрбум төгрөг буюу улсын дүнд 1.4 хувийг эзэлж байна.

Манай улсын соёл урлагийн салбарын харилцааг бие даасан хууль тогтоомжоор зохицуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг тодорхойлж, түүнд дэмжлэг үзүүлэх асуудлыг хуульчилсан ч уг дэмжлэгийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалт дутагдалтай байна.

Олон улсын чиг хандлагын дагуу бүтээлч авьяас билгийг нөхөн сэргээгдэх нөөц байдлаар хөгжүүлэх гол салбар болгон, энэ салбарын улс орны хөгжилд үзүүлэх нөлөөлөлийг нэмэгдүүлэх, олон улсын хөгжилтэй нийцүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2020 онд гаргасан “Далд эдийн засгийг хэмжих судалгаа, тооцоо 2015-2018 он” судалгааны тайланд Монгол Улсын нийт далд эдийн засгийн хэмжээ 2018 оны байдлаар 2971.9 тэрбум төгрөг байгаа нь нийт эдийн засгийн 9.2 хувийг бүрдүүлж, далд эдийн засагт эзлэх хамгийн их дүн буюу 1556.4 тэрбум төгрөг ногдож байжээ. Монгол Улсад далд эдийн засгийн албан бус секторын үйлдвэрлэлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээг нарийн тогтоосон судалгаа байхгүй ч, далд эдийн засгийн албан бус секторын бүртгэгдээгүй үйлдвэрлэгчид болон судалгаанд хамрагдаагүй бизнес эрхлэгчдийн тоонд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээний салбарт үйлдвэрлэл эрхэлж байгаа буюу гар урлал эрхлэгчид, чөлөөт уран бүтээлчид хамаарч байгаа нь энэ салбарт бүртгэл, мэдээллийн тогтолцоог бий болгох шаардлага байгааг харуулж байна.

Мөн “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын “R-Урлаг, үзвэр, тоглоом наадам” ангилалд соёлын үзвэр болон олон нийтийг хамарсан тоглоом наадам, урлагийн тоглолт, музейн үйлчилгээ, чөлөөт цагийн үйл ажиллагааг хамруулдаг тул Монгол Улсын хувьд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийгэм, эдийн засгийн үр дүнг зөвхөн дээрх үйл ажиллагааны хүрээнд тодорхойлон гаргаснаар үндэсний тооцооны системийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал дахь 19 салбарын хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын тоон мэдээллийг бодитой гаргах, түүний эдийн засаг дахь нөлөөллийг тооцох үзүүлэлт хангалтгүй байгааг илтгэж байна.

Түүнчлэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах бусад үйл ажиллагааг буюу “кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэл” үйл ажиллагааг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын J-Мэдээлэл холбоо, “Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл” үйл ажиллагааг C-Боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбар, дэд салбараас түүвэрлэн гаргах, нэгтгэхийн зэрэгцээ тодорхойлолт, үзүүлэлтийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулах хэрэгцээ үүсэж байна.

Цаашид соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, түгээх, ашиглах үйл ажиллагааны бүхэл гинжин холбоог олон улсын хэмжээнд харьцуулах боломжийг бий болгох зорилгоор Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА), Бүтээгдэхүүний тодорхойлолт, түүнийг кодчилох уялдаат систем (УС), Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, (ЭЗБҮАСА), Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (АМОУСА) зэрэгт боломжит ангиллуудыг уялдуулан ашиглах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл, хэлбэрийг цогцоор нь шийдвэрлэх зохицуулалт хэрэгтэй байна.

Бүтээлч авьяас чадварыг хөгжүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцийг нэмэгдүүлэн, санхүү, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, мэдлэг, сайн туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэн, дижитал шилжилтийг эрчимжүүлэн, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгааг хөхиүлэн дэмжиж, экосистемийг хөгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх нь чухал байна.

Түүнчлэн өнөө цагт соёлын бүтээлч үйлдвэрлэлд оролцогч талуудаас шинэ мэдлэг, ур чадвар, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг шаардаж байгаа тул соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд салбарт хөдөлмөр эрхлэгчдийг чадавжуулах, дотоодын зах зээлийг тэлэх, экспортыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бүрдүүлэх, тогтвортой хөгжил, дижитал технологи, харилцаа холбоо, боловсрол зэрэг салбар дундын уялдааг хангасан бодлого, удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Уг салбарын үйл ажиллагаанд соёлын болон үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж үйлчилж байгаа боловч өөрийн орны өвөрмөц онцлогийг хадгалан, нөөц боломж, технологийн хурдацтай хөгжил, дижитал шилжилт зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж давамгайл соёлын нөлөөлөл болон дэлхийн эдийн засгийн өрсөлдөөнийг даван туулах, мэдлэгт суурилсан эдийн засгийг цогцоор нь төрийн бодлогоор дэмжих зохицуулалт тусгагдаагүй байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль, тогтоомжийн тухай хуулийн 22.1.1 дэх заалтад заасны дагуу анхдагч хуулийн төсөл байна.

Хуулийн төсөлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хэлбэр, удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон дор дурдсан харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төслийг дараах агуулгаар боловсруулна:

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зарчим, хамрах хүрээг тогтооно;

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг, дэмжлэгийн хэлбэрийг тусгана;

- Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлно;

- Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэх, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний эдийн засаг болон бусад салбарт нөлөөлөх нөлөөллийг тооцох, нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар тусгана;

- Бүх шатны төрийн байгууллагуудын чиг үүрэг, төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, хамтын удирдлагын байгууллагын уялдаа холбоог тусгана:

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт мэдлэг солилцох, тасралтгүй хөгжих тогтоолцоог бий болгоно;

- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт үндэсний соёлын агуулгыг хадгалах, хамгаалах талаар тусгана.

- Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болохтой холбоотой асуудлыг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх орчин бүрдэж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явц нэмэгдэнэ.

Төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр тодорхой болж, салбарын түншлэл, хөрөнгө оруулалт, хамын ажиллагаа өргөжнө.

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, түгээхтэй холбоотой үе шат бүрд бүртгэл, мэдээллийн тогтолцоо нэвтэрч, соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг хэмжих боломж бүрдэнэ.

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжирч, гадаад зах зээлд өрсөлдөх боломж бүрдэн, ажлын байр нэмэгдэж, бүс, орон нутгийн өвөрмөц соёлын онцлогт тулгуурласан, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бүтээлч кластерууд бий болно.

Үндэсний үнэт зүйлийг бэхжүүлэх, үндэсний болон гадаад контентийн зохистой харьцааг бий болгох боломж бүрдэнэ.

Мэдлэгт суурилсан бүтээлч эдийн засгийн суурийг тавьж, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар Монгол хүний шавхагдашгүй баялаг оюуны бүтээлийг сурталчлах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлэх замаар шинэ ажлын байр бий болгох, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд

шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль болон холбогдох бусад хуулийн төслийг тус тус боловсруулна.

---o0o---